

“Монгол, Хятадын дурсамжууд” ном Бээжин хотноо хэвлэгдэв

Монгол, Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойд зориулан Хятадын ахмад дипломатчдын клубээс санаачлан дипломат харилцаа бүхий улс орнуудтайгаа хамтран гаргадаг “Тэд нар ба бид нар” цувралын хүрээнд энэхүү дөрвөн бүлэгт дурсамжийн номыг монгол, хятад хэлээр эрхлэн гаргажээ. Хятад хэлний хэвлэлийн нэр нь “中国和蒙古国的故事”. Монгол хэлний хэвлэл нь 348 хуудастай. Ерөнхий редактораар БНХАУ-аас Монгол Улсад суух Элчин сайд асан Гао Шүмао ажилласан бол монгол хэлнээ орчуулах ажлыг тус хүрээлэнгийн Хятад судлалын салбарын эрдэмтэн судлаачид хариуцсан байна.

Энэхүү ном хоёр улсын харилцааны сайнтай саартай хөгжлийн үйл явцад оролцож, хоёр орны харилцааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан, өөр өөр цаг хугацаанд ажиллаж амьдарч байсан, мөн өдгөө ч үйл хэргээ үргэлжлүүлсээр буй дипломатчид, зохиолчид, орчуулагчид, эрдэмтэд, бизнесмэнүүд зэрэг адил бус мэргэжлийн 24 хүний дурсамж, дуртгалаар бүтжээ. Эдгээр хүмүүс нь хоёр улсын шинэ үеийн харилцааны зам дахь анхдагчид, гэрчүүд тул тус тусынхаа туулсан амьдрал түүхийг олон өнцгөөс өргөн хүрээг хамарч дүрслэсэн бөгөөд Монгол, Хятадын харилцаа өнөөгийн өндөрлөгт хүрч хөгжсөн амжилт амар хялбараар олдоогүй гэдгийг дор бүрнээ илэрхийлжээ.

Уншигч Та энэхүү дурсамжийн номоос холбогдох сэдвээр бүтээгдсэн судалгааны бүтээлүүдэд тэр болгон тусгагдаж чаддаггүй үйл явдалд оролцогч хувь хүмүүсийн торгон мэдрэмж, сэтгэл зүрхнээс урган гарсан сонин содон үг өгүүлбэрийг олж уншин Монгол, Хятадын харилцааны өнгөрсөн хийгээд өнөөгийн асуудлаарх мэдлэгийн хүрээгээ өргөжүүлэн тэлэх боломжтой юм.

*Мэдээ бэлтгэсэн:
Эрдэм шинжилгээний дэд ажилтан, доктор (Ph.D)
Дамдиндоржийн Базардорж*